



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 6/6

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.1.4, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан (Эрүүл мэндийн сайдын багц) 3 нэрийн, нийт 10,381,387,993.00 (арван тэрбум гурван зуун наян нэгэн сая гурван зуун наян долоон мянга есөн зуун ерэн гурав) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг нэгдүгээр хавсралтад заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан (Эрүүл мэндийн сайдын багц) нэмэлт санхүүжилтийн 9 нэрийн, нийт 3,400,617,760.00 (гурван тэрбум дөрвөн зуун сая зургаан зуун арван долоон мянга долоон зуун жар) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдугаар хавсралтад заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчид (капиталжуулан) бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Батпүрэв, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч В.Оюумаа болон хавсралтад заасан аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020-2024 онд барьж ашиглалтад оруулсан хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох, бүртгэлд тусгах асуудлыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу эзэмшигч байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

3.3 Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

133603691
28-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оныдугаар сарынны өдрийн
.....дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦ)-ЭЭР БАРЬСАН ТӨРИЙН БОЛОН
ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ (БАРИЛГА БАЙГУУЛАМЖ)-ИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт		Орон нутгийн өмчид бүртгэх аймаг, Ашиглагч байгууллага
				Огноо	Дугаар	
1	Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга (Хөвсгөл аймга, Мөрөн сум Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газрын эзэмшлийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, зорьгоүй, 1 давхар, тэнхлэгээрээ 21.0м*12.0м, (гадна цахилгаанны шугам, цэвэр бохир усны, дулааны шугам, холбооны кабель, гэрэлтүүлэг, Хог хадгалах байр, дизель генератор, халаалтын насос явган зам, талбай)	819,789,202.00	2024.10.01	БАҚД-67-0006/24	Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар, Хөвсгөл аймгийн Мөрөн сум дахь "Энэрэл" өрхийн эрүүл мэндийн төв
2	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Нөхөн үржихүйн зөвлөх поликлиникийн өргөтгөлийн барилга (Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 11 дүгээр хороо, Эмнэлгийн өргөтгөлийн барилга, өөрийн эзэмшлийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, зорьтой, 4 давхар, тэнхлэгээрээ 21.0м*33.0м өргөтгөлийн барилга (гадна цахилгааны шугам, гадна цэвэр бохир усны шугам, явган болон авто зам, дулааны шугам, дэд өртөөний тоноглол, дизель генератор, лифт)	6,445,799,791.00	2024.06.05	БА-118/2024	Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 11 дүгээр хороо дахь Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв.

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт		Орон нутгийн өмчид бүртгэх аймаг, Ашиглагч байгууллага
				Огноо	Дугаар	
3	Эрүүл мэндийн төвийн барилга (Өмнөговь аймаг, Сэврэй сум дахь Эрүүл мэндийн төвийн барилга, өөрийн эзэмшлийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, зоорьгүй, 2 давхар, тэнхлэгээрээ 30.0м*37.5м, 15 ортой, (гадна цахилгааны шугам, цэвэр бохир усны, холбооны шугам, гэрэлтүүлэг, дулааны шугам, хог хаягдал хадгалах шугам, хог хаягдал барилга 6.0м*4.0м байр, морг 6.0м*7.0м, граж моторын барилга 9.7м*6.0м, гэрэлтүүлэг-10ш, сүүдрэвч-1ш, явган 373м2 болон авто зам талбай 1080м2)	3,115,799,000.00	2024.10.25	У-2024/78	Өмнөговь аймгийн Орон нутгийн өмчийн газар, Өмнөговь аймаг, Сэврэй сум дахь Эрүүл мэндийн төв
НИЙТ ДҮН						
			10,381,387,993.00			
			(арван тэрбум гурван зуун наян нэгэн сая гурван зуун наян долоон мянга есөн зуун ерэн гурав)			

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны..... дугаар сарынны ний өдрийн
..... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН (НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТЭЭР)
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Барилга байгууламж ашиглалтад оруулсан улсын комиссын актын дугаар	Орон нутгийн өмчид хүлээн авч бүртгэх (хариуцах байгууллага)
1	Хэнтий, Өмнөдэлгэр сумын ЭМТ-ийн барилга	392,756,590.00	52/2022	Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газар
2	Ховд, Дөргөн сумын ЭМТ-ийн барилга	265,770,729.00	ББКД/69/2022	Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газар
3	УБ, БЗД, Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилга	1,819,118,769.00	БА-053/2024	Нийгмийн эрүүл мэндийн төв
4	Баян-Өлгий, Ногооннуур сумын ЭМТ-ийн барилга	76,686,389.00	25/2021	Баян-Өлгий аймгийн Орон нутгийн өмчийн газар
5	Дундговь, Хулд сумын ЭМТ- ийн барилга	59,218,616.00	41/2020	Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газар
6	Хэнтий, Хэрлэн Өлзийт тосгоны ЭМТ-ийн барилга	312,482,374.00	21/2021	Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газар
7	УБ, БЗД, 16-р хороо ӨЭМТ- ийн барилга	366,784,293.00	БА-051/2022	Нийслэлийн өмчийн харилцааны газар
8	Архангай, Хайрхан сумын ЭМТ-ийн барилга	22,900,000.00	ББАОКД-2021/41	Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газар
9	Баян-Өлгий, Улаанхус сумын ЭМТ-ийн барилга	84,900,000.00	19/2021	Баян-Өлгий аймгийн Орон нутгийн өмчийн газар
НИЙТ ДҮН		3,400,617,760.00 (гурван тэрбум дөрвөн зуун сая зургаан зуун арван долоон мянга долоон зуун жар)		